



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2005 оны 4 сарын 22 өдөр

дугаар 158

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг гарган мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан 2005 оны эхний хагас жилд багтаан батлуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Р.Зоригт/-т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2005 оны ...
... сарын 22-ны өдрийн ...
158 дугаар захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар / цаашид "газар" гэх / нь нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд Нийслэлийн Засаг даргаас Хүнс, хөдөө аж ахуйн салбарын асуудлаар шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, биелэлтийг хангуулах үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газар нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд хөдөө аж ахуйг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэх, мал аж ахуй, газар тариалан, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, чанар, хүртээмжийг сайжруулах, хөдөө аж ахуйг аливаа эрсдэлээс хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

1.3. Газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Хүнсний тухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Тариалангийн тухай хууль, Таримал ургамлын үр, сортын тухай хууль болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг Даргын захирамж, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль тогтоомжууд, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

1.4. Газар нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, ил тод, шударга ёсыг хангах зарчмыг баримтлан ажиллана.

1.5. Газар нь Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас мэргэжил, арга зүйн удирдлагаар хангагдаж, Нийслэлийн Засаг Дарга, түүний орлогч, Тамгын газарт ажлаа тайлагнана.

1.6. Газар нь тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банканд харилцах данстай байна.

Хоёр. Газрын удирдлага зохион байгуулалт

2.1. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг Дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

2.2. Газар нь ажлаа жил, улирлаар төлөвлөж, улирал, хагас, бүтэн жилээр тайлан төлөвлөгөөний биелэлт гаргана.

2.3. Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлөх бөгөөд мэргэжилтнүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулж биелэлтийг дүгнэн ажиллана.

2.4. Газрын дарга холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын цалин, урамшлыг тогтоож, эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

2.5. Газрын дүрмийг Нийслэлийн Засаг дарга батлана.

2.6. Газрын дарга нь төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээнд тусгасач бүтээгдэхүүнийг Төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлж, төсвийг зарцуулна.

2.7. Газар нь ажлаа төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, мэдээ, мэдээлэл, гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар яам, агентлаг, бусад холбогдох газруудтай хууль, эрх зүйн хэм хэмжээнд уялдуулан зохицуулна.

Гурав. Газрын үүрэг

3.1. Газар нь өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд болон өөрийгөө бүрэн тэтгэх чадвартай аж ахуйд тулгуурласан, байгаль, цаг уурын өөрчлөлтөнд зохицсон, үр ашигтай үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

3.2. Хүнс, хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор байгаль, эдийн засаг, санхүү, хүний нөөцөө зохистой ашиглаж, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, үр ашиг, бүтээгдэхүүний чанар, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэн хүнсний үйлдвэрийн болон нийслэлийн хүн амын хүнсний эрэлт хэрэгцээнд нийцсэн аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх, мал аж ахуй, газар тариалан, хүнсний салбарын тогтвортой хөгжлийг хангана.

3.3 Байгалийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, оюуны багтаамж ихтэй, эрсдэл багатай, байгаль орчинд халгүй хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийг хөгжүүлэх явдлыг бүх талаар дэмжинэ.

3.4 Сүүний жижиг, дунд үйлдвэрүүдэд чанар сайтай, эрүүл ахуйн шаардлага хангасан түүхий эд нийлүүлэх, улмаар нийслэлийн хүн амын сүү, цагаан идээний өдөр тутмын хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5 Ган, халуунд тэсвэртэй үр тариа, буурцагт ургамал, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж, улмаар зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.

3.6 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тэдгээрийн зах зээлд эзлэх хувийг өсгөж, шинэ технологи эзэмшихийг дэмжинэ.

3.7 Махны үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлж бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг уртасгах, хямд төсөр олон нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.8 Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн техник, технологийн шинэчлэл хийх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, стратегийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, хангамжийг тогтвортой байлгах, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд лизингийн худалдаа, төлбөрт үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.9 Байгаль, цаг уур, эдийн засаг, гадаад, дотоод зах зээлд нийцсэн хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.

3.10 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох: нэн тэргүүнд фермерийн болон эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, мал сүрэг, тариалангийн үйлдвэрлэлийг байгалийн гамшгаас хамгаалах, даатгалын тогтолцоог боловсронгуй болгох боловсруулах үйлдвэрүүдийг зээл татварын бодлогоор дэмжих чиглэлээр хууль, эрх зүйн орчинг шинэчлэх, асуудлыг боловсруулах холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.11 Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад шаардлагатай үед мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, тодорхой нөхцөлөөр гэрээ байгуулан хамтран ажиллана.

3.12 Хүнс хөдөө аж ахуйн салбарт олгосон гадаадын зээл тусламжийн хөрөнгийг нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгод ашиглах асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэн зохицуулна.

3.13 Түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх, боловсруулах технологийг боловсронгуй болгон сав баглаа боодлыг сайжруулах, бөөний худалдааны төв, бирж, сүлжээ бий болгох асуудлыг дэмжинэ.

3.14 Хоршоо, фермерийн аж ахуйг хөгжүүлэх санаачилга хөдөлгөөнийг өрнүүлж ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгоход дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

3.15 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын ажиллагсад, иргэдэд үндэсний уламжлалт арга ажиллагааг эзэмшүүлэх, шинжлэх ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, зах зээлд өндөр нэр хүнд бүхий үйлдвэрлэл, бүтээгдэхүүнийг сурталчилах ажлыг зохион байгуулах зорилгоор дадлагын бааз, сургалтын төв ажиллуулна.

3.16 Хүнс, хөдөө аж ахуйн салбарт ашиглах дотооддоо үйлдвэрлэх бс томжгүй техник, сэлбэг, тоног төхөөрөмж, эрдэс бордоо, ургамал хамгааллын бодис, таримал ургамлын шинэ сортын үр, суулгац, өндөр ашиг шимт үржлийн мал, амьтан, тэдгээрийн үр хөврөл, үрийг импортын татвар болон нэмэгдсэн өртгийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

3.17 Болзошгүй гамшиг, онцгой байдлын үед нийслэлийн хүн амыг хангах зөвлөхгүй шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн /мах, гурил г.м./ үйлдвэрлэх, бэлтгэн нөөцлөх тогтолцоог бүрдүүлж ажиллана.

3.18 Хүнсний бүтээгдэхүүнийг ариутгах, аюулгүй байдлыг хамгаалах, дэвшилтэт сав, баглаа боодлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхийг дэмжинэ.

3.19 Согтууруулах ундааны үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө өгч, аттестатчилал явуулна.

3.20 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, эрхлэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.21 Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн загвар аж ахуйг бий болгоход дэмжлэг тусалцаа үзүүлнэ.

3.22 Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.23 Малын үүлдэр угсааг сайжруулж ашиг шимийг нэмэгдүүлэхэд шалгарсан удмын хээлтүүлэгч болон цэвэр үүлдрийн малын үр, хөврөлийг ашиглах замаар биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.

3.24 Гойд ашиг шимт малыг илрүүлэн бүртгэлд авч гэрчилгээ олгон баталгаажуулж, малын үзэсгэлэн, дуудлага худалдааг холбогдох газруудтай хамтран зохион байгуулна.

3.25 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, үржлийн ажил үйлчилгээг дүүрэгт хариуцан гүйцэтгэх албадыг мэргэжлийн удирдлагаар хангана.

3.26 Нийслэлийн хэмжээнд үржлийн ажилд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эм урвалжийн төлөвлөлт санхүүжилтын асуудлаар нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлнэ.

3.27 "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг байгууллага аж ахуйн нэгж, айл өрх иргэдийн дунд өргөн хүрээтэй зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, байгалийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.28 Усалгаатай газар тариаланг өргөжүүлэх ажиллагааг эрчимжүүлж, хамгаалагдсан хөрсний болон төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж нийслэлийн иргэдийн хүнсэнд шинэ ногоо хэрэглэх хугацааг уртасгана.

3.29 Байгаль орчин, бүтээгдэхүүний чанарт сөрөг нөлөөгүй аргаар тариалангийн хог ургамал, өвчин, хортон шавьж, мэрэгчидтэй тэмцэх арга ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3.30 Газар тариалангийн техник шинэчлэлд гадаадын зээл, тусламжийг өргөн ашиглах, дотооддоо техникийн зарим эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах ажлыг дэмжих, бага оврын техник, тоног төхөөрөмжийн хангамжийг дээшлүүлэх, зохицуулна.

3.31 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын судалгаа, үйлдвэрлэлийн мэдээ, мэдээллийн сүлжээг буй болгон иргэдэд хүргэх үйлчилгээ үзүүлнэ.

3.32 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр шинжлэх ухааны ололт, дэвшлийг нэвтрүүлэх төслийг захиалах, хэрэгжүүлэх, хяналт тавих, зохицуулна.

3.33 Нийслэлийн мал аж ахуй эрхлэх зөвшөөрөгдсөн бүсийн газар эзэмшил, хувьчлалын асуудалд санал өгнө.

3.34 Төрийн өмчийн цөм сүргийн удмын санг хамгаалах ажлыг хэрэгжүүлнэ.

3.35 Өрх бүрийг хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах хөдөлгөөнд хамруулж хүнсний хангамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.36 Холбогдох хууль тогтоомж, газрын дотоод журмын дагуу ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, туршлага судлуулах зэрэг сургалтын зохистой арга хэлбэр, хамрах хүрээг өргөжүүлэх талаар шат дараалсан арга хэмжээг авна.

3.37 Газрын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийг хадгалалт, хамгаалалт төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллана.

3.38 Газрын даргын нийтлэг хэм хэмжээ, тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст хүргүүлж хянуулна.

3.39 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын талаар гарсан УИХ, Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний болон дэд хөтөлбөр төсөл, НИТХурал, түүний Тэргүүлэгчдийн хурлын тогтоолууд болон Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан дэд хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг улирал бүр гаргана.

3.40 Тус газар нь холбогдох УИХ, Засгийн газар, НИТХ, Нийслэлийн Засаг даргын гаргасан тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэн, биелэлтийг улирал бүр Хүнс, хөдөө аж ахуйн яамны дотоод мэдээллийн графикийн дагуу мэдээ тайланг графикт хугацаанд гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

Дөрөв. Газрын эрх

4.1 Байгууллагын эд хөрөнгө, төсвийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

4.2 Аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийн дагуу зөвлөгөө өгөх, санал хүсэлтийг дээд шатны байгууллагад уламжлах асуудал боловсруулж шийдвэрлүүлнэ.

4.3 Хүнсний үйлдвэр, мал аж ахуй, газар тариалангийн салбарт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйл ажиллагаа нь Монгол улсын хууль тогтоомжийг зөрчсөн бол хууль, мэргэжлийн хяналтын байгууллагад уламжилж холбогдох арга хэмжээ авахуулна.

4.4 Хүнс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын гаргасан зөрчил дутагдлын талаар хэвлэл мэдээлэллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж сэрэмжлүүлэг өгнө.

4.5 Холбогдох дээд байгууллагын эрх олгосноор салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

Тав. Хүлээх хариуцлага

5.1 Газрын дарга, ажилтанууд бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд Төрийн албаны тухай хууль болон холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1 Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

6.2 Энэхүү дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийн тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

-----oOo-----